



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/225

Чингис хот

Г Хэрлэн голын эрэг орчмын хог хаягдлыг  
цэвэрлэх, цаашид авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол улсын Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, 24 дүгээр зүйлийн 24.1, Улсын Их Хурлын 2010 оны 24 дүгээр тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны А-121 дүгээр тушаал, Хэнтий аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 22 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэрлэн гол сумын нутаг дэвсгэрээр дайран урсдаг сумдууд Хэрлэн голын эрэг дагуух газрыг сумынхаа байгууллага аж ахуйн нэгж, баг, малчны бүлэг нөхөрлөл, бэлчээр ашиглалтын холбоодод захирамжаар хуваарилан хариуцуулахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2. Хэрлэн голын эрэг орчмын газар нутгийг хуваарилсан нэгж талбарын хил хязгаарыг нарийн тогтоож тэмдэгжүүлэн хариуцах албан байгууллага, талбайн дугаар хил хязгаарыг тэмдэглэсэн сурталчилгааны самбар гаргаж нийтэд харагдах газар байршуулан хариуцсан талбайн цэвэрлэгээ, бохирдлын байдалд хяналт тавьж ажиллахыг Цэнхэрмандал, Дэлгэрхаан, Баянмөнх, Дархан, Мөрөн, Баянхутаг, Хэрлэн, Батноров, Баян-Овоо сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хэрлэн голын эрэг дагуух нийтийн цэвэрлэгээг өөрийн сумын хэмжээнд 2018 оны 6 дугаар сарын 25-наас 7 дугаар сарын 05-ны дотор зохион байгуулж захирамжаар байгууллагуудад хуваарилан хариуцуулсан талбайг тэмдэгжүүлж хүлээлгэн өгөхийг холбогдох сумдын Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Б.Дархантөр/, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Д.Баярхүү/ нарт үүрэг болгосугай.

4. Хэрлэн, Баян-Овоо, Баянмөнх сумын төв, Цэнхэрмандал сумын Хэрлэнгийн гүүр орчмын зорчигч, амрагч олноор цуглардаг усанд ордог цэгүүдэд түр хогийн

2//.

цэгийг шинээр хийж байршуулан тэмдэгжүүлэх, голын эрэг дагуу Гол усаа бохирдуулахгүй байх, гол ус үерийн аюулаас болгоомжлоход чиглэгдсэн сурталчилгааны самбар, тэмдэг тэмдэглэгээг байршуулж, явуулын эргүүл ажиллуулахыг дээрх сумдын Засаг дарга, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хэрлэн голын Сав газрын захиргаанд үүрэг болгосугай.


5. Урин дулааны улиралд задгай усаа дагаж Хэрлэн гол дагуух бэлчээрийн даацыг үлэмж ихээр хэтрүүлснээс голын ургамлан бүрхэвч, бургасны ургалт, голын усны тэжээгдэл, бохирдолд ихээр нөлөөлж байгаатай холбогдуулан зуншлага бэлчээрийн байдалтай уялдуулан Хэрлэн голын татмаас өвөлжөө хаваржааг гаргах, цаашид татамд орж ирэх малын тоог цөөлөх тогтвортой бодлогыг хэрэгжүүлж ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Сум суурин газрын орчимд гахай чөлөөтэй бэлчиж голын эргийн хөрсийг эргүүлж ургамлан бүрхэвчийг устгах явдал түгээмэл гарч байгаатай холбогдуулан голын эргээс 5-аас доошгүй километрт гахайн байр барих аж ахуй эрхлэх зөвшөөрлийг олгож, голын эрэг дагуу гахай бэлчээхийг хориглосугай.

7. Хэрлэн сумын хуучин хогийн цэгээс хог хийсч Хэрлэн гол орчмыг бохирдуулж байгааг таслан зогсоож хуучин хогийн цэгийг дарж булшлах ажлыг чанартай шуурхай хийж Чингис хотоос зүүн тийш зам дагуу Хэрлэн голын чигт тархсан хогийг 2018 оны 7 дугаар сарын 05-ны дотор цэвэрлүүлэхийг Хэрлэн сумын Засаг дарга (Ц.Идэрбат)-д үүрэг болгосугай.

8. Захирамжийг сурталчилж хэрэгжилтийн явц байдлын дүн мэдээг нэгтгэн үр дүнг тооцон 2018 оны 12 дугаар сарын 05-ны дотор танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Б.Дархантэр/, захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА